



## **БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

<b>Тендер шалгаруулалтын нэр</b>	<b>“Шивээ овоо” ХК-д Белаз техникийн хөдөлгүүрийн тос нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалт</b>
<b>Тендер шалгаруулалтын дугаар</b>	<b>ШО/201902133</b>
<b>Огноо</b>	<b>2019.06.24</b>

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: **2019.06.24**

Тендер шалгаруулалтын нэр:

**Белаз техникийн хөдөлгүүрийн тос нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалт**

Тендер шалгаруулалтын дугаар: **[ШО/201902133]**

**[“Шивээ Овоо” ХК ]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[ Белаз техникийн хөдөлгүүрийн тос]**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татан авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг **[ 2019 оны 7-р сарын 1 ]** өдрийн **[ 16 цаг ]** --аас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[ 2019 оны 7-р сарын 1]-ны өдрийн [16 цаг 30 минутад ] [ Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, “Шивээ Овоо” ХК, Худалдаа хангамжийн албаны өрөө]**<sup>1</sup>-д нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг, бусад мэдээллийг [tender.gov.mn](http://tender.gov.mn), [shivee-ovoо.mn](http://shivee-ovoо.mn) сайтаас болон доорх утсаар лавлаж болно.

**[ Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, “Шивээ Овоо” ХК, Худалдаа хангамжийн алба ]**

**[ Утас: 88886339, 99029879, 99903261]**

---

<sup>1</sup> Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

### Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| <b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>      | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.   |

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Компаний танилцуулага</li> <li>2. Компаний улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>3. Шүүхийн төрөлжсөн архивын газрын тодорхойлолт</li> <li>4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт</li> <li>5. Сүүлийн [ <b>2018 он</b>] аудитлагдсан санхүүгийн тайлан</li> <li>6. Сүүлийн [ <b>2018 он</b>] туршлагын мэдээлэл</li> <li>7. Гэрээний үнэ, хугацаанд техникийн шаардлага хангасан барааг хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл</li> <li>8. Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлсэн тохиолдолд захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан мэдэгдэл</li> <li>9. Тендерт шалгарсан тохиолдолд тендерт санал болгосон хугацаанд барааг нийлүүлээгүй тохиолдолд захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан мэдэгдэл</li> <li>10. Итгэмжлэгдсэн лабораторын шинжилгээний дүгнэлт</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн аж ахуй нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч тендерийн материалыг цахим хэлбэр /PDF/-ээр ирүүлнэ.</p> <p>Огноо: <i>[2019 оны 7 дугаар сарын 1-ны өдөр]</i></p> <p>Цаг: <i>[ 16 цаг ]</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>[ Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг, өөрийн оффисе, ХХАлбаны өрөө]</i></p> <p>Огноо: <i>[2019 оны 7 дугаар сарын 1-ны өдөр]</i></p> <p>Цаг: <i>[ 16 цаг 30 минут ]</i></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт:

№	Материалын нэр	Эдийн дугаар	Нэгж	Тоо	Ашиглагдах техник	Зориулалт	Тайлбар
1	Хөдөлгүүрийн тос	CI-4 SAE15W40	литр	6600	2013 оны БелАЗ 7555В, TEREX	Cummins, КТ-19, дизель хөдөлгүүрт хэрэглэгдэхэд зориулагдсан байна	Эсвэл түүнтэй дүйцэхүйц

Уг техникт ашиглаж болно гэсэн итгэмжлэгдсэн лабораторын дүгнэлтийг ирүүлнэ.

### 2. Бараа хүргэх газар: [ Говьсүмбэр аймаг, “Шивээ Овоо” ХК-ний сэлбэгийн склад ]

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Хөдөлгүүрийн тос	CI-4 SAE15W40	6600	л	“Шивээ Овоо” ХК-ийн ИТСтанцын склад	7 хоног	14 хоног	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(**“Шивээ Овоо” ХК**)-ийн гүйцэтгэх захирал Ц. Энхтүвшин танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

---

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[тоо]</i> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах          | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |



---

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Барааны шалгалт туршилтыг захиалагчийн заасан бараа хүргэгдэх эцсийн цэгт холбогдох хүмүүсийг байлцуулан хийж гүйцэтгэн хүлээн авна.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><ul style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан зарлагын баримт, нэхэмжлэхийн хувь;</li><li>2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>4) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ul> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаа (ГЕН-5)</b>  | 5.1. Баталгаа нь барааг ашиглалтад орсоноос хойш 12 сар байна.  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний төлбөрийг барааг хүлээн авсан актыг үндэслэн 30-45 хоногийн дотор шилжүүлнэ.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>                  | 9.1. Алданги оногдуулах хувь: [ 0]<br><br>Алдангийн нийт дүн: [ 0]  |

---

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>3</sup>

БАТЛАВ  
“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

БАТЛАВ  
“.....” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ЭНХТҮВШИН

..... / овог нэр /

**ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

20... оны .... дүгээр сарын ....

№

Сэвхүүл

**Нэг талаас:** Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд байрлах, 2004879 регистрийн дугаартай “Шивээ-Овоо”ХК/*цаашид “Худалдан авагч” гэх/* түүнийг төлөөлж Худалдаа, Хангамжийн Албаны дарга Б.Чинбэлэг,

**Нөгөө талаас:** .....хот, .....дүүрэг, .....тоотод байрлах, ..... тоот регистрийн дугаартай “.....” ХХК /*цаашид “Худалдагч” гэх/* түүнийг төлөөлж .....албан тушаал овог нэр /*цаашид хамтад нь “Талууд” гэх/* ТБОНӨХБАҮХАТХуулийн 33.1, 33.2 дахь заалт болон Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг үндэслэн дараах нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг заалт**

1.1. Гэрээний нөхцөлийн дагуу Худалдагч нь Хавсралт № 01-д заасан биет байдлын болон эрхийн доголдолгүй сэлбэг, эд материал /цаашид “Бараа” гэх /, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх ба худалдан авагч нь барааг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд төлбөрийг хийнэ.

1.2. Гэрээний нийт үнэ [ **тоо** ] / .....үсэг..... / төгрөг болно.

1.3. Гэрээний нийт үнэд [**НӨАТ орсон**] болно.

1.4. Барааны үнэд барааг “Шивээ овоо”ХК-ний уурхай хүргэх тээврийн зардал [**орсон**] болно.

1.5. Талуудын аль нэг хуулийн этгээдийн хувьд өөрчлөн байгуулагдсан нь энэхүү гэрээг цуцлах болон үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

1.6. Талууд харилцан тохиролцон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.

1.7. Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

**Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа**

2.1. Худалдагч нь барааг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш хуанлийн .... хоногийн дотор “Шивээ Овоо” ХК – ийн хадгалах агуулахад нийлүүлнэ.

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

---

### *Гурав. Барааны чанар*

3.1. Худалдагчаас нийлүүлж байгаа бараа нь үйлдвэрлэгчийн техникийн нөхцөл, мөрдөгдөж буй стандартад нийцсэн, худалдан авагчийн хүсэлтийг хангасан байна.

3.2. Худалдан авагч гэрээний дагуу ирсэн барааг шалгаж авна. Худалдаж авсан барааг шалгах болон ашиглах явцад илэрсэн доголдлыг худалдагчид доголдол илэрсэн өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор мэдэгдэнэ.

### *Дөрөв. Төлбөрийн нөхцөл*

4.1. Худалдан авагч нь урьдчилгаа төлбөр төлөхгүй болно.

4.2. Худалдан авагч тал барааг хүлээн авсан актыг үндэслэн төлбөрийг хуанлийн /30-45/ хоногт багтаан шилжүүлнэ.

### *Тав. Худалдагчийн үүрэг*

Худалдагч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

5.1. Гэрээ нь хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гэрээний хавсралтад заасан барааг хуанлийн 3 хоногийн дотор худалдан авагчид нийлүүлнэ.

5.2. Барааг тээврийн хэрэгсэлд ачихаас ажлын [3] хоногийн өмнө албан бичиг, телефакс, утас, email, захидлаар худалдан авагчид бараа нийлүүлэх талаар мэдэгдэнэ.

5.3. Чанарын доголдолгүй эд материалыг Худалдан авагчийн заасан газар, тогтоосон хугацаанд нийлүүлэх үүрэгтэй.

5.4. Худалдагч тал худалдан авагч талд барааг хүлээлгэн өгөх хүртэлх бүх эрсдэлийг бүрэн хариуцна.

5.5. Барааг дагалдан ирэх паспорт, чанарын тодорхойлолт, баталгааны гэрчилгээ, бусад шаардлагатай баримт бичгийг барааны хамт худалдагчид шилжүүлэн өгнө.

5.6. Энэхүү гэрээг байгуулахтай холбогдон олж мэдсэн, Худалдан авагчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар бусдад задруулахгүй байх, гэрээнд зааснаас өөрөөр ашиглахгүй байх үүрэгтэй.

### *Зургаа. Худалдан авагчийн үүрэг*

Худалдан авагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

6.1. Худалдан авагч нь худалдагчаас өөрийн техник, хэрэгслийн хэрэгцээ, шаардлагыг хангахуйц чанар, стандартын шаардлага хангасан барааг захиалсан тоо хэмжээгээр цаг хугацаанд нь саадгүй тасралтгүй нийлүүлж, хангахыг шаардах эрхтэй.

6.2. Худалдагчаас барааг нийлүүлэх хугацааг мэдэгдсэнээс хойш ажлын [3] хоногийн дотор барааг хүлээж авах бэлтгэлийг хангасан байна.

6.3. Барааг хүлээж авахдаа тоо, чанар, иж бүрдлийг шалгаж, акт үйлдэж зохих бичиг баримтыг бүрдүүлнэ.

### *Долоо. Бараа нийлүүлэх*

7.1. Худалдан авагч талын гаргасан захиалгын хуваарийн дагуу цаг хугацаанд нийлүүлнэ.

7.2. Худалдан авагч Барааг хүлээн авах акт үйлдсэн бол түүнийг хөрөнгө хүлээн авсанд тооцно.

### *Найм. Талуудын хариуцлага*

8.1. Худалдагчийн буруугаас биет байдлын болон эрхийн доголдолтой бараа нийлүүлсэн бол худалдагч нь уг доголдлыг арилгах үүрэг хүлээнэ.

8.2. Энэ гэрээний нөхцөлийг зөрчсөнөөс аль нэг талд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгана. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал нотолно.

---

8.3. Барааг дагалдан ирэх паспорт, чанарын тодорхойлолт, баталгааны гэрчилгээ, бусад шаардлагатай баримт бичгийг барааны хамт худалдагчид шилжүүлэн өгнө.

8.4. Худалдагч нь техникийн тодорхойлолтод зааснаас өөр шаардлага хангахгүй бараа нийлүүлэх мөн нийлүүлэгдсэн бараанд гарсан аливаа гэмтэл согогийг өөрийн зардлаар ажлын 7 хоногт багтаан үнэ төлбөргүйгээр сольж нийлүүлнэ.

#### *Ес. Давагдашгүй хүчин зүйл*

9.1. Энэхүү гэрээг байгуулсны дараа давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас аль нэг тал болон талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

9.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

#### *Арав. Маргааныг шийдвэрлэх*

10.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

10.2. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### *Арван нэг. Гэрээний үйлчлэх хугацаа*

11.1. Гэрээний үйлчлэх хугацаа гэрээ дүгнэж акт үйлдэн, тооцоо нийлэлт хийгдсэнээр гэрээ дуусгавар болно.

11.2. Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож сунгаж болно.

11.3. Энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө дараах үндэслэлүүдээр цуцалж болно. Үүнд:

11.3.1. Гэрээгээр тогтоосон хугацааны дотор худалдан авагч төлбөрөө төлөөгүй нөхцөлд, түүнчлэн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нийлүүлэлт хийх боломжгүй болсон тухайгаа худалдан авагчид албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд худалдагчийн санаачилгаар хугацаанаас өмнө цуцалж болно.

11.3.2. Худалдан авагч барааг үргэлжлүүлэн худалдан авахаас татгалзсан тухайгаа худалдагчид албан ёсоор бичгээр мэдэгдэж тооцоо нийлэн нийлэгдсэн барааны төлбөрөө бүрэн төлж барагдуулсан тохиолдолд мөн гэрээнд заасан хугацаанд хавсралтад заасан бараагаа нийлүүлээгүй тохиолдолд худалдан авагчийн санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно.

11.3.3. Худалдагч нь чанар стандартын шаардлага хангахгүй бараа нийлүүлсэн тохиолдолд худалдан авагчийн санаачилгаар хугацаанаас өмнө цуцалж болно.

11.3.4. Монгол Улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр

11.3.5. Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр

#### *Арван хоёр. Бусад заалт*

12.1. Гэрээг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

12.2. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол улсын иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

12.3. Энэхүү гэрээг талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

---

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

\_\_\_\_\_ С.Ариунзул  
Санхүү Хангамжийн Хэлтсийн дарга

\_\_\_\_\_ Б.Чинбэлэг  
Худалдаа хангамжийн албаны дарга

\_\_\_\_\_ Н.Энхжаргал  
НББА-ны дарга, Ерөнхий нягтлан бодогч

\_\_\_\_\_ Э.Мандахнаран  
Хуулийн зөвлөх

Хаяг: Говьсүмбэр аймаг, Шивээговь сум  
42020 Сэвхүүл  
Утас: (976)-7054-6464  
Факс:(976)-7054-6363

**ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

\_\_\_\_\_ / овог нэр /  
Албан тушаал

Хаяг: .....хот, .....дүүрэг, .....хороо,  
.....ТООТ  
Утас: .....  
Данс:...

\_\_\_\_\_ **ТООТ ХУДАЛДАХ,ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ**

**ХАВСРАЛТ № 01 / Үнийн хуваарь/**

20.... оны ..... дүгээр сарын .....өдөр

Сэвхүүл

№	Эдийн нэр	Эдийн дугаар	Ашиглах техник	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хөдөлгүүрийн тос	CI-4 SAE15W40	Белаз 7555В	литр	6600		
	<b>ДҮН</b>						
	<b>НӨАТ</b>						
	<b>НИЙТ ДҮН</b>						

**Гэрээ байгуулсан:**

Худалдан авагчийг төлөөлж:

/ \_\_\_\_\_ / Б.Чинбэлэг/ /ХХА-ны дарга/

/ \_\_\_\_\_ / Н.Энхжаргал/ /НББА-ны дарга, Ерөнхий нягтлан бодогч/

Худалдагчийг төлөөлж:

/ \_\_\_\_\_ / Овог нэр /

Албан тушаал